



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505,  
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081  
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: [azdtg@selenge.gov.mn](mailto:azdtg@selenge.gov.mn)  
Цахим хуудас: [www.selenge.gov.mn](http://www.selenge.gov.mn)


2024.07.19 № 01/901  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_


### СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ

Сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны  
үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ,  
үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэв.

Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 10 хуудастай.

  
И.ЛКАГВАДОРЖ





**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

**2024 ОН**

# ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Сэлэнгэ аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

## ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “Журам батлах тухай” А/458 захирамжийг тус тус баримтлав.

Бодлогын баримт бичиг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дээрх журмын 6.2.1-д зааснаар хувиар илэрхийлэн үнэлсэн, харин тоо, чанараар илэрхийлэх боломжгүй зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг мөн журмын 6.2.2-т заасан аргачлалаар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын ил тод байдлыг хангах үйл ажиллагааг дээрх журмын 6.3-д заасан аргачлалаар тус тус үнэлэв.

### Үнэлгээ хийх журамд заасны дагуу ерөнхий үнэлгээг тооцохдоо:

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд орсон 6 үзүүлэлтийн дундаж нь нийт үнэлгээний 40 хувь,
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаарх үнэлгээнд орсон 13 үзүүлэлтийн дундаж нь нийт үнэлгээний 30 хувь,
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн талаарх үнэлгээнд орсон 31 үзүүлэлт нь нийт үнэлгээний 30 хувь болно.

### Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Аймгийн Хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Үндэсний болон аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт

### **Байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаарх үнэлгээнд:**

- Аймгийн Засаг даргын сумын Засаг даргыг батламжилсан батламжийн биелэлт
- Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан 2023 оны хамтран ажиллах гэрээний хэрэгжилт
- Сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Сумын төр, төсвийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан
- Хэрэглэгчийн үнэлгээний тайлан
- Аймгийн ИТХ, Засаг даргаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт
- Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилт
- Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль тогтоомжуудын хэрэгжилт
- Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, холбогдох дүрэм, журмын хэрэгжилт
- Багийн Засаг даргын үйл ажиллагаа, үр дүн
- Хүний нөөцийн бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт
- Монгол Улсын Засгийн газраас баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн хэрэгжилт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийж, хэрэгжүүлсэн ажлын тайлан

### **Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээнд:**

- Гэмт хэргийн өсөлт, бууралт,
- Цэргийн насны залуучуудын эрүүлжилт,
- Онцгой байдал, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан ажил, арга хэмжээ,
- Сумын орлогын төлөвлөгөөний биелэлт,
- Төсвийн зардлын гүйцэтгэл,
- Өр,
- Авлага,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөвлөгөөний биелэлт,
- Сумын нийт малын тоонд үхэр сүргийн эзлэх хувь,
- Нийт малчин иргэдийн тоонд эрчимжсэн үхрийн аж ахуй эрхэлж буй иргэдийн эзлэх хувь,
- Нийт малын дунд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын эзлэх хувь,
- Шинээр бий болгосон засварласан худаг, уст цэгийн тоо,
- Үр тариа, төмс, хүнсний ногоо тариалалт,
- Ой хээрийн түймрийн тоо, учруулсан хор хөнөөл,

- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, нэмэгдүүлсэн байдал /хувиар/,
- Биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулсан байдал,
- Төвлөрсөн хог хаягдлын цэгийн хадгалалт, хамгаалалт,
- Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалт хамгаалалт,
- Шинэ ажлын байр бий болгосон байдал,
- Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь,
- Хамран сургалтын хувь,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь,
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хангалт, хамрагдалт,
- Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт,
- Эхийн эндэгдэл,
- Нялхсийн эндэгдэл,
- Халдварт өвчний гаралт,
- Нийт иргэдийн дунд ажилгүй иргэдийн эзлэх хувь,
- Соёлын төвийн үйл ажиллагаа,
- Гэр бүл, хүүхэд залуучуудад үзүүлж буй нийгэм, соёлын үйлчилгээ, түүний үр дүн,
- Номын сангийн үйл ажиллагааны түвшин

Сумын Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг 0.05 үржүүлж, 0-5 хүртэл оноод шилжүүлэн дүгнэсэн.

## ДҮГНЭЛТ

Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж **80.67** хувь, байгууллагын үндсэн үйл ажиллагааны дундаж дундаж **83.31** хувь, эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт **76.1** хувь буюу ерөнхий үнэлгээ **80.09** хувьтай байна.

Үнэлгээг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

### Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн

№	Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	Бодлогын баримт бичгийн үнэлгээ	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	70	0.4	3.5
		Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	80		4
		Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	80		4
		Хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	90		4.5
		Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	84		4.2
		Үндэсний болон аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт	80		4
<b>Дундаж</b>			<b>80.67</b>	<b>32.27</b>	<b>4.03</b>
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Сумын Засаг даргын батламжийн биелэлт	80	0.3	4
		Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт	79		3.95
		Сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	92		4.6
		Сумын төр, төсвийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	90		4.5
		Хэрэглэгчийн үнэлгээний тайлан	70		3
		Аймгийн ИТХ, Засаг даргаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт	80		4
		Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилт	90		4.5
		Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль тогтоомжуудын хэрэгжилт	94		4.7

	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, холбогдох дүрэм, журмын хэрэгжилт	78		3.9
	Багийн Засаг даргын үйл ажиллагаа, үр дүн	60		3
	Хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт	100		5
	Монгол Улсын Засгийн газраас баталсан "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийн хэрэгжилт	80		4
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийж, хэрэгжүүлсэн ажлын тайлан	100		5
	<b>Дундаж</b>	<b>83.31</b>	<b>24.99</b>	<b>4.17</b>
3	Эдийн Засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт /31 үзүүлэлт/	76.1	22.83	3.80
	<b>Ерөнхий үнэлгээ</b>		<b>80.09</b>	

## ЗӨВЛӨМЖ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлагналт хангалтгүй байгаа тул бүртгэл хяналтыг сайжруулах, орон нутагт үр дүнтэй зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүд, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, хэрэгжилтэд дүгнэлт хийж, 2024 оны төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх нь зүйтэй байна.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодитой, биелэгдэхүйц, шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц байхаар төлөвлөх, гүйцэтгэлийн тайлан нь иж бүрэн, алдаагүй, итгэл үнэмшил төрүүлэхүйц үр дүнд суурилсан байхад анхаарах.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжүүлэн хуульд заасан мэдээллийг ил тод, нээлттэй болгож, иргэдийг үнэн зөв, ойлгомжтой мэдээллээр хангах, мэдээллийн үйлчилгээг шуурхай, хялбар болгоход анхаарч **Shilen.gov.mn** мэдээллийн системд байгууллагын мэдээллийг байршуулан хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дор дурдсан асуудалд анхаарал хандуулж, удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

### **Бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах талаар:**

1. Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг өссөн дүнгээр тайлагнах, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэх;

2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралаар хэлэлцүүлэн иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

3. Урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хөрөнгийн эх үүсвэр, статистик тоон мэдээлэлд үндэслэн орон нутгийн онцлог давуу талыг тусган сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан ажиллах.



### **Бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар:**

1. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн суманд хамааралтай заалтуудын хэрэгжилтийг түүвэрлэн тайлагнах, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахад тухайн жилийн өсөн нэмэгдсэн дүнгээр тайлагнах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний сумдад нэр заагдсан болон нийтлэг хамааралтай заалтуудыг тодорхойлж, хэрэгжилтийг ханган ажиллах;

2. Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээг эрчимжүүлэхэд анхаарч тухайн жилийн хэрэгжилтийг бүрэн хангах;

3. Үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хэрэгжилтийг үр дүнд чиглүүлэн зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах;

4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган, тайлагнан ажиллах.

### **Хэрэгжилтийн тайлагналтыг сайжруулах талаар:**

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг богино хугацааны үр дүн, дунд хугацааны үр нөлөөг илэрхийлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, үнэн зөв тайлагнаж байх;

2. Санхүүжилтийн гүйцэтгэл, эх үүсвэрийг арга хэмжээ бүрээр бүрэн тайлагнаж, жилийн эцсийн байдлаар өссөн дүнг хагас жилийн гүйцэтгэлтэй тулган хянаж байх;

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлангаргах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг баримтлах;

4. Жилийн эцсийн тайланг журамд заасан хугацаанд ирүүлэх.

### **Байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаар:**

Сумын Засаг даргын батламжийн биелэлтийн хэрэгжилтийг тайлагнахдаа хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг дурдан үнэн бодитойгоор тайлагнах;

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд гэрээнд заагдсан арга хэмжээ бүрийг сумдын төр төсвийн байгууллагын болон салбарын албан хаагчдад хариуцуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган улирал бүр хэрэгжилтийг тайлагнан, анхан шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гэрээнд заасан хугацаанд ирүүлж байх;

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох холбогдох хууль тогтоомжийн дагуу хугацаанд хариуг хүргүүлэн ажиллахад анхаарах;

Хэрэглэгчийн үнэлгээ нь захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн дүнг хэлэх бөгөөд "Захиргааны байгууллага салбарын болон орон нутгийн хэмжээнд бодлогын

баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг хийж болно.

Захиргааны актын хувийн хэргийн бүрдэл, хууль эрх зүйн үндэслэл үнэн зөв авч хууль хэрэглээг сайжруулан, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл хяналтыг сайжруулан ажиллах;

Архивын тухай хууль болон архив албан хэрэг хөтлөлтийн стандарт шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах, мөн 2025 оноос эхлэн хос бичгээр төрийн албан хэргийг хөтлөхтэй холбоотойгоор үндэсний бичгийн мэдлэгийг төрийн албан хаагчдад эзэмшүүлэх, сургалтыг тогтмол зохион байгуулах хэвлэмэл хуудсийг стандартын дагуу хэвлүүлэн ашиглах,

Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн судалгааг гаргаж хүний нөөцийн сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлон ажлын байран дээрх суралцаж, хөгжих боломжийг нэмэгдүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах;

Багийн Засаг дарга нарын үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн илтгэх хуудсыг багийн Засаг дарга нарын тайланд үндэслэн бодитойгоор үнэлж, шалгуур үзүүлэлт, үнэлгээг хамт ирүүлэх шаардлагатай.

#### **Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:**

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийн ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу байгууллагын тайланг зурган мэдээ баримтаар баримтжуулан ирүүлэх ба эх сурвалжийг тайлангийн доод хэсэгт дурдаж өгөх;

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.12-т заасны дагуу байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг ажиллуулж, цахим хуудсаар мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангах;

3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан мэдээллийг ил тод, нээлттэй байлгах арга хэмжээ авч ажиллах;

4. Байгууллагын цахим хуудсыг “Төрийн байгууллагын цахим хуудсанд байршуулах шаардлага MNS 6285:2017 стандарт”-ын дагуу хөтөлж, хэвшүүлэх;

#### **Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, үр нөлөөг сайжруулах талаар:**

1. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон зорилтот түвшин, хүрсэн үр дүнг үндэслэн үнэн зөв, бодитой үнэлэх;

2. Тайланг хууль болон журамд заасан тогтоосон хугацаанд ирүүлэх, хэрэгжилтийг хэт нуршуу биш үр дүнг тайлагнасан хэлбэрээр ирүүлэх;

3. Энэхүү дүгнэлт зөвлөмжийг үндэслэн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд ирүүлэн ажиллах зэрэг болно.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

МНОА0005 9055053